

ДАРХАН УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дархан Уул аймгийн "Дархан хотын соёл амралтын хүрээлэн" ОНӨААТҮГ-ын
2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДАА-2023/16/НА-СТА-ОНА

<p>Цахим хуудас: www.audit.mn Дархан Уул аймаг, Дархан сум 2024 он</p>	<p>Газрын дарга, тэргүүлэх аудитор: Ш.Мөнхбаяр Утас:70373089, 99023682 Цахим хаяг:munkhbayarsh@audit.gov.mn Аудитын менежер: У.Батсүрэн Утас:99023682 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn Ахлах аудитор: С.Батцэцэг Утас:99377479 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Пийк-Ом Аудит ХХК Захирал: Б.Жаргалсайхан Утас:99862066 Цахим хаяг:peakomaudit@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ДАРХАН ХОТЫН СОЁЛ АМРАЛТЫН
ХҮРЭЭЛЭН ОНӨААТҮГ-ЫН ДАРГА
Л.ТАМИР ТАНАА

2024.03.15 № 148
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Дархан хотын соёл амралтын хүрээлэн” ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Дархан хотын соёл амралтын хүрээлэн” ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

“Дархан хотын соёл амралтын хүрээлэн” ОНӨААТҮГ нь тайлант онд 1,318,757.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 1,943,123.6 мянган төгрөгийн зардал гарган, 624,366.1 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. “Дархан хотын соёл амралтын хүрээлэн” ОНӨААТҮГ-ын 2023 оны жилийн үйл

ажиллагааны төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 49 арга хэмжээг төлөвлөж 100.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12 дугаар сарын 31	2023 оны 12 дугаар сарын 31
1	ХӨРӨНГӨ	-	-
1.1	Эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	1,280,200.53	58,520,047.29
1.1.2	Дансны авлага	31,526,204.82	2,778,743.00
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	-	-
1.1.4	Бусад авлага	-	-
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	65,041,781.08	71,029,810.66
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	-	-
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	97,848,186.43	132,328,600.95
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.1	Үндсэн хөрөнгө	7,595,568,496.82	8,840,620,599.45
1.2.2	Биет бус хөрөнгө	22,867,602,000.00	22,883,472,222.28
1.2.3	Биологийн хөрөнгө	-	-
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	30,463,170,496.82	31,724,092,821.73
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	30,561,018,683.25	31,856,421,422.68
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	-	-
2.1	ӨР ТӨЛБӨР	-	-
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.1	Дансны өглөг	-	-
2.1.1.2	Цалингийн өглөг	-	-
2.1.1.3	Татварын өр	-	-
2.1.1.4	НДШ-ийн өглөг	-	-
2.1.1.5	Богино хугацаат зээл	-	-
2.1.1.6	Хүүний өглөг	-	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.1	Урт хугацаат зээл	-	-
2.1.2.2	Нөөц / өр төлбөр/	-	-
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	-	-
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	-	-
2.3	Эздийн өмч	-	-
2.3.1	Төрийн өмч	30,302,599,731.07	32,228,894,779.07
2.3.2	Хувийн өмч	-	-
2.3.3	Хувьцаат өр төлбөр	-	-
2.3.4	Халаасны хувьцаа	-	-
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	-	-
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	-
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	-	-
2.3.9	Хуримтлагдсан ашиг	258,418,952.18	(372,473,356.39)
2.3.11	Эздийн өмчийн дүн	30,561,018,683.25	31,856,421,422.68
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	30,561,018,683.25	31,856,421,422.68

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/Төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12 дугаар сарын 31	2023 оны 12 дугаар сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	401,315,436.03	596,811,247.84
2	Борлуулалтын өртөг	-	-
3	Нийт ашиг (алдагдал)	401,315,436.03	596,811,247.84
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүгийн орлого	-	-
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	636,767,291.80	721,946,300.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	-	-
11	Санхүүгийн зардал	779,663,775.65	1,943,123,651.59
12	Бусад зардал	-	-
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	258,418,952.18	(624,366,103.75)
19	Орлогын татварын зардал	-	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	258,418,952.18	(624,366,103.75)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	258,418,952.18	(624,366,103.75)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлийн зөрүү	-	-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23.3	Бусад олз (гарз)	-	-
24	Орлогын нийт дүн	258,418,952.18	(624,366,103.75)
25	Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)	-	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгөрөгөөр/

	Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	30,302,599,731.07	258,418,952.18	30,561,018,683.25
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-
3	Залруулсан үлдэгдэл	30,302,599,731.07	258,418,952.18	30,561,018,683.25
6	Зарласан ногдол ашиг	-	-	-
7	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-
9	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	30,302,599,731.07	258,418,952.18	30,561,018,683.25
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	(6,526,204.82)	(6,526,204.82)
11	Залруулсан үлдэгдэл	30,302,599,731.07	251,892,747.36	30,554,492,478.43
13	Өмчид гарсан өөрчлөлт	1,926,295,048.00		1,926,295,048.00
14	Зарласан ногдол ашиг	-	-	-
15	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	(624,366,103.75)	(624,366,103.75)
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-
17	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	32,228,894,779.07	(372,473,356.39)	31,856,421,422.68

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12 дугаар сарын 31	2023 оны 12 дугаар сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	941,315,436.03	1,318,327,547.84
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	-	-
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
1.1.4	Буцаан авсан албан татвар	-	-
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	540,000,000.00	721,946,300.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	401,315,436.03	596,381,247.84
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	770,793,255.50	1,125,394,851.08
1.2.1	Ажилагсад төлсөн	345,660,763.12	604,068,151.67
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	67,781,352.56	133,642,957.57
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	153,131,859.00	162,588,344.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	35,918,655.88	95,518,953.86
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	10,600,000.00	18,703,000.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	-	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	23,280,542.00	45,759,946.00
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	160,380.00	160,380.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	134,259,702.94	64,953,117.98
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	170,522,180.53	192,932,696.76
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого	-	-
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсаны орлого	-	-
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсаны орлого	-	-
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө боруулсаны орлого	-	-
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	-	-
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	169,241,980.00	135,692,850.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	169,241,980.00	130,692,850.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	5,000,000.00
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(169,241,980.00)	(135,692,850.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн	-	-
3.1.3	Төрөл бүрийн хандив	-	-
3.1.4	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	-	-

3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	-	-
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж төлсөн	-	-
3.2.4	Төлсөн ногдол ашиг	-	-
3.2.5	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,280,200.53	57,239,846.76
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,280,200.53
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,280,200.53	58,520,047.29

2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	2022 оны гүйцэтгэл	2023 оны		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт					
2	Нийт орлого	1,038,082,727.83	971,946,300.00	1,318,757,547.84	346,811,247.84	135.7
	Үүнээс: Цэвэр борлуулалт	540,000,000.00	250,000,000.00	59 6,811,247.84	346,811,247.84	238.7
	Бусад орлого	498,082,727.83	721,946,300.00	721,946,300.00	0.00	-
3	Нийт зардал	0.00	0.00	0.00	0.00	-
	а) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	0.00	0.00	0.00	0.00	-
	б) Ерөнхий удирдлагын зардал	779,663,775.65	971,946,300.00	1,943,123,651.59	947,456,141.59	197.5
	в) Үндсэн хөрөнгө данснаас хассан олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	
4	Цэвэр ашиг, алдагдал	258,418,952.18	0.00	(624,366,103.75)	(624,366,103.75)	

3. Аудитын илрүүлэлт

Залруулга

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой дараах 144,609.1 мянган төгрөгийн алдаануудыг залрууллаа. Үүнд:

- Санхүүгийн тайлан, үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайланд 84,388.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн ангилал буруу, үндсэн хөрөнгийн шинж чанар агуулаагүй бараа материалуудыг орлого авсан,
- Ашиглах жил оруулаагүй, бараа материалын шинж чанартай хөрөнгийг үндсэн хөрөнгөд бүртгэснээс 27,854.7 мянган төгрөгийн элэгдлийг санхүүгийн тайланд дутуу илэрхийлэгдсэн.

- Аж ахуйн аргаар хийсэн 32,366.4 мянга төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд төсвийн хөрөнгөөр худалдан авснаар бүртгэн тайлант үеийн үр дүнг бууруулсан.

Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 2.1.4 “Санхүүгийн бүртгэл, тайлан нь бодит баримт, тоо мэдээнд үндэслэсэн байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу залруулав.

Аудитаар нийт 6,374.7 мянган төгрөгийн зөрчил илэрч, 1,080.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 5,294.7 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 3 зөвлөмж өгсөн.

3.1 Төлбөрийн акт

1. Цалин хөлс, нэмэгдэл урамшуулалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Сахилгын шийтгэл ногдуулсан 3 ажилтанд сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй байхад 1,080.0 мянган төгрөгийн улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосон нь Хөдөлмөрийн тухай 123 дугаар зүйлийн 123.8-д “Хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл ажилтныг хөдөлмөрийн сахилгын шийтгэлгүйд тооцно”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2.7-д “Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

3.2 Албан шаардлага

1. Цалин хөлс, нийгмийн даатгалын тооцоололтой холбоотой асуудал

Илрүүлэлт: Цалингийн тооцооны хүснэгтийг НД-ын тулган шалгахад 5,294.7 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан, Нийгмийн даатгалын байгууллагатай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дахь “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 20 дугаар зүйлийн 20.2.7 дахь “аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө тусалцаа авах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгал, татварын байгууллагатай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулах албан шаардлага хүргүүлэх.

3.3 Зөвлөмж

1. Үндсэн хөрөнгийн тооллоготой холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд хагас жилийн тооллогын комиссыг томилж, тушаал гаргаагүй, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтад заасны дагуу ажилтан албан хаагчдын эд хөрөнгийн ашиглалтын бүртгэл тус бүрээр тоолоогүй, үндсэн хөрөнгийн тооллогыг товчоо тайлангаар тайлагнасан, хөрөнгийн чанар байдлыг тодорхойлоогүй зэргээр хөрөнгийн тооллогыг үр дүнгүй явуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.1-д “Тооллогын комисс нь эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах үүрэгтэй”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулах, цаашид алдаа зөрчил давтан гаргахгүй байх.

2. Үндсэн хөрөнгийн хадгалалт хамгаалалт, бүтэц орон тоотой холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус байгууллага нь Миний Монгол цэцэрлэгт хүрээлэн, Морин хуур цогцолбор, Дархан 50 цогцолборуудын нийт 493,047.0 мкв талбайд алсыг харагч, агаарын дугуй, морин тойруулга, гинжит тойруулга, чийрэгжүүлэх тоног төхөөрөмж зэрэг тоглоом, "Дүүжин гүүрийн байгууламж", гэрэлтэй гудамж, төрөл бүрийн хөшөө, биеийн тамирын, тоглоом, амралтын талбайнууд, нийтийн зам талбайн байгууламж, хашаа, хаалт, гэрэлтүүлэг, ногоон байгууламжийн зүлэг, бут сөөг, олон наст ургамал, мод, сүүдрэвч, сандал, хогийн сав, хог тээвэр, нийтийн ариун цэврийн барилга, био, зөөврийн нойл гэх мэт нэр төрөл их, онцгой шинж чанартай, гадаа талбайд тараан байршуулсан нийт 31.8 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий олон хөрөнгийн өнгө үзэмж, чанар, хэвийн ажиллагаа, арчилгаа, аюулгүй байдлыг хариуцан ажилладаг боловч ажиллагсдын тоо хүрэлцээгүй, орон тоог зөв төсөвлөн батлуулаагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3-т "*үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах*", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т "*Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх*" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тухайн байгууллагын үйл ажиллагаа явуулахад шаардлагатай орон тоог зөв төлөвлөн шийдвэр гаргах эрх бүхий байгууллагад хүргүүлэх, шийдвэр гаргуулах зөвлөмж хүргүүлэх.

3. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус байгууллага нь бэлэн мөнгөөр борлуулсан тоглоомын тасалбарын орлогыг "Билет борлуулалтын мэдээ" нэртэй дотоод тооцооны хүснэгтэд тусган кассын тайлан бэлтгэхгүйгээр шууд банкинд тушааж байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "*Ерөнхий нягтлан бодогч нь холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах үүрэгтэй*", Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалын хавсралтын 3.12-т "*Эрх бүхий ажилтан хураасан орлогоо өөрийн байгууллагын бүртгэлийн дансанд ажлын 1 хоногт багтаан тушааж сар бүрийн эцэст зарагдсан тасалбарын бүртгэл болон орлого цуглуулсан баримтын (зарагдсан тасалбараас өөрт үлдэх хувь) тооцоог гаргаж, тайланг тушаана*", 7.2-т "*Мөнгөн кассын нярав бэлэн мөнгөний гүйлгээ тус бүрийг кассын дэвтэрт бүртгэж, өдөр бүр кассын тайлан гаргаж кассын дэвтрийн хуудас бүрийг дугаарлан дэвтрийн сүүлчийн хуудасны тоог бичиж дараагийн ажлын өдрийн 12 цагаас хэтрүүлэхгүйгээр нягтлан бодогчид шилжүүлэн өгч хянуулж байна*" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тухайн байгууллагын мөнгөн хөрөнгийн данс хариуцсан ажилтан хураасан орлогоо өөрийн байгууллагын бүртгэлийн дансанд ажлын 1 хоногт багтаан тушааж сар бүрийн эцэст зарагдсан тасалбарын бүртгэл болон орлого цуглуулсан баримтын тооцоог гаргаж, тайланг тушааж хэвших, цаашид алдаа зөрчил давтан гаргахгүй ажиллах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5¹ дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн

¹ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ

авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийн ангилал буруу бүртгэсэн	1	84,388.1			1		1	84,388.1				
Ашиглах жил оруулаагүй, бараа материалын шинж чанартай хөрөнгийг үндсэн хөрөнгөнд бүртгэн элэгдэл илүү илэрхийлэгдсэн	1	27,854.7			1		1	27,854.7				
Аж ахуйн аргаар барьсан хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд төсвийн хөрөнгөөр худалдан авснаар бүртгэн тайлант үеийн үр дүнг бууруулсан.	1	32,366.4			1		1	32,366.4				
Дүн	3	144,609.1			3		3	144,609.1				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сахилгын шийтгэл ногдуулсан 3 ажилтанд үр дүнгийн урамшуулал олгосон	1	1,080.0	1	1,080.0								
Цалингийн тооцооны хүснэгтийг тулган шалгахад, НДШ-ын тайланттай 5,294.7 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан	1	5,294.7			1	5,294.7						

Тайлант онд хагас жилийн тооллогын комиссыг томилж, тушаал гаргаагүй, хөрөнгийн тооллогыг үр дүнгүй явуулсан байна.	1	-					1	-				
Ажиллагсдын тоо хүрэлцээгүй, орон тоог зөв төсөвлөн батлуулаагүй байна	1	-					1	-				
Бэлэн мөнгөөр борлуулсан тоглоомын тасалбарын орлогыг "Билет борлуулалтын мэдээ" нэртэй дотоод тооцооны хүснэгтэд тусган кассын тайлан бэлтгэхгүйгээр шууд банкинд тушааж байна.	1	-					1	-				
Дүн	5	6,374.7	1	1,080.0	1	5,294.7	3	-				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад хуулийн 6.4.8-д заасан бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрээс 30,103.4 мянган төгрөгийн 3 шийдвэрийг мэдээлээгүй байна.	1	30,103.4					1	30,103.4
Дүн	1	30,103.4					1	30,103.4
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1	30,103.4					1	30,103.4